



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 8/39

Хэрлэн сум

Шагналд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 Аймгийн Засаг даргын 2003 оны А/99 дүгээр захирамжаар батлагдсан аймгийн “Хүндэт тэмдэг” олгох журам, 2015 оны А/511 дүгээр захирамжаар батлагдсан “Хан Хэнтийн алдартан тэмдэг олгох журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн 99 жилийн ойн үндэсний их баяр наадмыг тохиолдуулан салбартаа олон жил үр бүтээлтэй ажиллаж, аймаг орон нутгийнхаа хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа нэр бүхий хүмүүсийг Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнахад 840,000 (найман зуун дөчин мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах болэмжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022  
05/29 07  
05  
... дугаар сарын...-ны  
... захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Нэр	Нэгжийн үнэ	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
1	Жуух бичиг хийлгэх зардал	14.000	60ш	840.000
	Нийт дүн			840.000